



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Өлзийт сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/38/СТА-ТШЗ

Баянхонгор хот. 2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 7044-2584 Цахим хаяг: munkhatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 7044-2424 Цахим хаяг: tsetsegmaad@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Должмаа

Утас: 88119345 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2019.01.25 № 2/104

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Өлзийт сумын ЗДТГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Өлзийт сумын ЗДТГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Өлзийт сумын ЗДТГ-ын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус салбарт мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

2519194

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Гүйцэтгэсэн горим сорилын дүнд илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн, жилийн эцсийн тооллогын бүртгэлээрх хөрөнгийн дүн санхүүгийн тайлан дахь хөрөнгийн дүнгээс 71,1 сая төгрөгөөр бага, тооллогын дүнг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, халаалтын өглөгийн 6,5 сая төгрөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй, үндсэн хөрөнгийн дахин үнэлээний бичилтийг буруу хийснээс дахин үнэлгээг 116,7 сая төгрөгөөр бага илэрхийлж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд ...бүх өр төлбөрийг заавал бүртгэнэ", Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 4.56 дахь заалт, 2017 оны 347 тоот тушаалын 8 дугаар заалтыг зөрчиж оршин байх, үнэлгээ, хэмжилт гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Өлзийт сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ЗДТГ-ын дарга М.Зоригтод танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлзийт сумын ЗДТГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлзийт сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.23-наас 2019.02.25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Б. Должмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Өлзийт сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.25-ны өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Өлзийт сумын ЗДТГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Өлзийт сумын ЗДТГ нь “Оновчтой бодлого зохицуулалтаар удирдаж, сум орноо манлайлан хөгжүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Өлзийт сумын ЗДТГ-ын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Өлзийт сумын ЗДТГ-ын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байхгүй.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Өлзийт сумын ЗДТГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд 46 оноотой үнэлэгдсэн тул мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзэж, томилогдсон аудитор аудитыг гүйцэтгэлээ.

Өлзийт сумын ЗДТГ санхүүгийн тайланг бэлтгэхдээ "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн Acolous 4.01, цалингийн Payroll программ хангамж ашигладаг байна.

Өлзийт сумын ЗДТГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Өлзийт сумын ЗДТГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Өлзийт сумын ЗДТГ-ын 2018 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 542273,5 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 10845,5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа. Гүйцэтгэлийн шатанд шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илрээгүй.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	0	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	2	8.20	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	2	8.20	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Санхүүгийн тайланд хийсэн залруулга:

1. Сумын ЗДТГ энэ оны 11 сард ашиглалтад орсон бөгөөд 11, 12 сарын төлбөрт 10107820 төгрөг төлөхөөс 3569240 төгрөг төлж, 6538580 төгрөгийн өглөгтэй атлаа санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байна.
2. Тайлант жилийн цалингийн зардлыг 34496 төгрөгөөр илүү, мөн дүнгээр НДШ-ийн зардлыг дутуу тусгасан байна. Мөн үр дүнгийн тайланд халаалтын зардал, гэрэл цахилгааны зардлыг 595392 төгрөгөөр зөрүүлж бичилт хийсэн.
3. Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бичилтийг буруу хийснээс санхүүгийн тайланд 116748847,15 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн зэрэг зөрчил илэрснийг санхүүгийн тайланд залруулав.

Аудитаар тогтоосон төлбөрийн акт:

1. 2.8.1.1 Орлогын данстай холбоотой асуудал

Тайлант онд акталсан үндсэн хөрөнгийг ИТХ-ын тогтоолтой тулган шалгахад 2017.11.01-ний өдөр ЗДТГ-ын дарга М.Батаа Баянлиг сумын ЗДТГ-ын дарга Г.Мөнхсүхтэй гэрээ байгуулж, байгууллагын эзэмшилд байсан, акталсан Кама маркын хогны автомашиныг 4.0 сая төгрөгөөр худалдах, худалдан авах гэрээ байгуулж, 2017.12.31-ний өдөрт багтааж, төлбөрийг төлөхөөр тохиролцсон боловч 2017.12.22-ны өдөр 3.0 сая төгрөг төлж, үлдэгдэл 1.0 сая төгрөгийг төлөөгүй байхад авлагаар бүртгээгүй, 2018 онд төлүүлээгүй зөрчил завсрын аудитаар илэрсэн.

Энэ нь Оршин байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4, 14.4.2 дахь хэсэг, 2 талын байгуулсан гэрээний 3 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Төлбөрийн акт тогтоов.

2. 2.8.1.2 Орлогын данстай холбоотой асуудал

Өлзийт сумын ЗДТГ-ын нярав бусад хангамжийн бараа материалын тайлан гаргаагүй байхад нягтлан бодогч 2018.06.30-нд 5020.0 мянган төгрөгийн үтрэмийн будаа, 6950.8 мянган төгрөгийн тэжээлийн хивэг, 4162.5 мянган төгрөгийн өвс, нийт 16133.3 мянган төгрөгийн бараа материалыг зарлагадсан байна. Сумын ОНХС-ийн дансанд өвс, тэжээлийн орлогоор 17206.4 мянган төгрөг орж, зарлагадсан өвс тэжээлийн үнээс 1070.8 мянган төгрөгөөр зөрсөн бөгөөд үүний учрыг тодруулан шалгахад 2016 онд 6500.0 мянган төгрөгөөр 1100 боодол өвс авсныг орлогод аваагүй зарлагадснаас хүмүүсээс нийт 7190.7 мянган төгрөгийн авлага үүссэн байхад түүнийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй зөрчил завсрын аудитаар илэрсэн.

Энэ нь Тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Төлбөрийн акт тогтоов.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Өлзийт сумын ЗДТГ-т чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 314674,2 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 311370,4 мянган төгрөг буюу 99,5 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 1311,1 мянган төгрөгөөр хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Өлзийт сумын ЗДТГ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2018 оны 1-9 сарын шилэн дансны мэдээллийг 2018 оны 11 дүгээр сард хийсэн нийцлийн аудитаар шалгасан байна. Санхүүгийн тайлангийн аудитаар 10-12 сарын мэдээллийг шилэн дансанд байршуулсныг шалгахад 10-12 саруудад төсвийн гүйцэтгэлийн мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн, байгууллагын даргын А/152 тоот тушаалыг буруу харуулж хавсаргасан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Өлзийт сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Өлзийт сумын ЗДТГ 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн

сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Өлзийт сумын ЗДТГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн тодруулгын тайлангийн дүнгээс тооллогын бүртгэлийн дүн 52324806 төгрөгөөр, бараа материалын дүн тооллогын бүртгэлээс 18742139 төгрөгөөр, нийт хөрөнгийн дүн 71066945 төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх заалтыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Тооллого, тооцоог цаг хугацаанд нь хийгээгүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийн тооллогыг чанартай гүйцэтгэж, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан маягтуудыг бүрэн хөтөлж байх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна.

3.2.1 Илрүүлэлт:

Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн санхүүгийн тайланг дур мэдэн засварласан байна.

3.2.2 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10 дахь заалтыг хэрэгжүүлж, Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн санхүүгийн тайланд залруулга хийхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 05 дугаар 01-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/Төгрөгөөр/
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>76,023,096.00</u>	<u>71,161,348.00</u>
33	АВЛАГА	439,250.00	1,100,000.00
335	Бусад авлага	439,250.00	1,100,000.00
3351	Байгууллагаас авах авлага	367,250.00	1,100,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	72,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	75,583,846.00	70,061,348.00
351	Түүхий эд материал	23,696,611.00	26,268,769.00
35110	Тусгай зориулалттай материал	23,696,611.00	26,268,769.00
354	Хангамжийн материал	39,977,235.00	33,792,579.00
35410	Бичиг хэргийн материал	1,294,075.00	1,631,075.00
35420	Аж ахуйн материал	4,569,175.00	5,298,975.00
35450	Барилгын засварын материал	216,680.00	596,580.00
35470	Бусад хангамжийн материал	33,897,305.00	26,265,949.00
35600	Мал амьтад	11,910,000.00	10,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>941,368,435.12</u>	<u>1,780,559,127.94</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	941,368,435.12	1,780,559,127.94
392	Биет хөрөнгө	940,761,264.51	1,767,465,141.37
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,387,079,667.00	2,010,086,023.11
39202	Хуримтлагдсан элэгдэл	-788,556,112.73	-425,236,555.71
39203	Авто-тээврийн хэрэгсэл	157,834,152.00	140,401,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-73,470,548.09	-73,049,211.41
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	72,769,683.00	98,869,683.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-48,081,605.58	-53,425,799.56
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	59,968,284.87	88,885,284.87

Өлзийт сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39208	Хуримтлагдсан элэгдэл	-24,864,217.97	-27,455,882.93
39214	Бусад үндсэн хөрөнгө	289,731,626.00	00.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-110,039,463.99	00.00
39216	Дуусаагүй барилга, байгууламж	17,400,000.00	7,400,000.00
39217	Ном	989,800.00	989,800.00
393	Биет бус хөрөнгө	607,170.61	13,093,986.57
39301	Програм хангамж	834,000.00	1,834,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-834,000.00	-834,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	3,311,840.00	15,129,840.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-2,704,669.39	-3,035,853.43
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,017,391,531.12</u>	<u>1,851,720,475.94</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>6,538,580.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	6,538,580.00
413	Өглөг	00.00	6,538,580.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	6,538,580.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,017,391,531.12</u>	<u>1,845,181,895.94</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,017,391,531.12	1,845,181,895.94
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	771,855,589.00	783,673,589.00
51101	Өмч: - төрийн	771,855,589.00	783,673,589.00
512	Хуримтлагдсан үр дүн	150,008,585.03	884,920,122.04
51210	Өмнөх үеийн үр дүн	150,008,585.03	150,008,585.03
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	734,911,537.01
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	95,527,357.09	176,588,184.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,017,391,531.12</u>	<u>1,851,720,475.94</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	514,611,890.00	1,277,185,060.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	48,187,305.00	917,206,820.00
120	Нийтлэг татварын бус орлого	48,187,305.00	917,206,820.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	48,187,305.00	917,206,820.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,151,000.00	2,210,800.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	45,036,305.00	914,996,020.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	466,424,585.00	359,978,240.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,945,585.00	42,190,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,945,585.00	42,190,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	339,780,834.00	315,274,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	339,780,834.00	315,274,200.00
1330	Төсвийн захирагчдаас	115,543,305.00	00.00
133003	Хөрөнгийн	115,543,305.00	00.00

Өлзийт сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	154,861.00	2,513,240.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	154,861.00	2,513,240.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	454,460,326.52	507,524,764.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	454,460,326.52	507,524,764.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	398,257,961.52	483,220,115.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	194,632,662.00	198,164,161.00
210101	Үндсэн цалин	178,788,662.00	181,586,961.00
210105	Гэрээт ажлын хөлс	15,844,000.00	16,577,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,621,800.00	23,839,521.00
210201	Тэтгэврийн даатгал	18,151,898.00	15,994,362.28
210202	Тэтгэмжийн даатгал	1,083,581.00	1,982,770.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,433,215.00	1,586,215.34
210204	Ажилгүйдлийн даатгал	198,001.00	388,742.59
210205	Эрүүл мэндийн даатгал	1,755,105.00	3,887,429.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,559,151.00	24,872,709.00
210301	Гэрэл, цахилгаан	2,898,018.00	4,224,829.00
210302	Түлш, халаалт	10,661,133.00	20,647,880.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,469,025.88	40,841,142.00
210401	Бичиг хэрэг	4,565,220.00	4,848,500.00
210402	Тээвэр, шатахуун	21,419,360.00	15,815,277.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,478,000.00	2,949,023.00
210404	Ном, хэвлэл	00.00	93,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	447,000.00	3,236,800.00
210408	Бараа материал акталсны зардал	7,559,445.88	13,898,542.00
2105	Нормативт зардал	2,162,000.00	00.00
210502	Хоол, хүнс	1,462,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	700,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,777,370.00	2,420,890.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	6,600.00
210604	Урсгал засвар	2,777,370.00	2,414,290.00
2107	Томилолт, зочны зардал	2,998,000.00	3,688,000.00
210702	Дотоод албан томилолт	2,998,000.00	3,688,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,147,177.00	16,435,740.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,794,425.00	16,371,390.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	228,252.00	00.00
210807	Газрын төлбөр	24,500.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108,890,775.64	172,957,952.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,099,685.00	78,151,976.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	178,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	104,491,090.64	94,627,976.82
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,202,365.00	24,304,649.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	2,499,900.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	2,499,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,220,061.00	3,073,240.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	154,861.00	2,513,240.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,594,500.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,670,700.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,800,000.00	560,000.00

Өлзийт сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,982,304.00	14,827,800.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,982,304.00	14,827,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	3,903,709.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,903,709.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	60,151,563.48	769,660,295.18
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	34,748,758.17
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	5,845,912.39
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	28,902,845.78
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-34,748,758.17
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	60,151,563.48	734,911,537.01

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	354,032,280.00	362,189,040.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,151,000.00	2,210,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,151,000.00	2,210,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,151,000.00	2,210,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,151,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,210,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	350,881,280.00	359,978,240.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,945,585.00	42,190,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,945,585.00	42,190,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	339,780,834.00	315,274,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	339,780,834.00	315,274,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	154,861.00	2,513,240.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	154,861.00	2,513,240.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	354,032,280.00	362,189,040.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	354,032,280.00	362,189,040.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	297,829,915.00	313,414,391.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	194,147,592.00	198,164,162.00
210101	Үндсэн цалин	178,303,592.00	181,586,962.00
210105	Гэрээт ажлын хөлс	15,844,000.00	16,577,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,621,800.00	23,839,520.00
210201	Тэтгэврийн даатгал	16,891,640.00	15,682,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,145,852.00	1,989,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,433,215.00	1,637,000.00

Өлзийт сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210204	Ажилгүйдлийн даатгал	286,463.00	490,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,864,630.00	4,040,420.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,260,501.00	18,334,129.00
210301	Гэрэл, цахилгаан	2,700,000.00	4,224,829.00
210302	Түлш, халаалт	11,560,501.00	14,109,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,338,400.00	18,702,423.00
210401	Бичиг хэрэг	2,464,700.00	3,035,500.00
210402	Тээвэр, шатахуун	11,594,200.00	10,603,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,300,000.00	2,969,923.00
210404	Ном, хэвлэл	590,000.00	490,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	389,500.00	1,604,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,956,700.00	5,989,100.00
210602	Тавилга	00.00	3,700,000.00
210604	Урсгал засвар	2,956,700.00	2,289,100.00
2107	Томилолт, зочны зардал	2,998,000.00	3,688,000.00
210702	Дотоод албан томилолт	2,998,000.00	3,688,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,551,337.00	39,807,557.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,339,445.00	39,151,907.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	220,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	191,892.00	219,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	25,750.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,800,000.00	00.00
210807	Газрын төлбөр	90,000.00	90,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,955,585.00	4,889,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,455,585.00	4,191,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	698,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,202,365.00	48,774,649.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	26,729,900.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	26,729,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,220,061.00	3,313,240.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	154,861.00	2,513,240.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,594,500.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,670,700.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,800,000.00	800,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	14,827,800.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	14,827,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,982,304.00	3,903,709.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,982,304.00	3,903,709.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	771,855,589.00	95,527,357.09	150,008,585.03	1,017,391,531.12
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	771,855,589.00	95,527,357.09	150,008,585.03	1,017,391,531.12
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	771,855,589.00	95,527,357.09	150,008,585.03	1,017,391,531.12
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	81,060,827.81	00.00	81,060,827.81
Тайлант үеийн үр дүн	11,818,000.00	00.00	734,911,537.01	746,729,537.01
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	783,673,589.00	176,588,184.90	884,920,122.04	1,845,181,895.94

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	342,931,750.00	329,949,530.00	315,274,200.00	313,581,291.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	342,931,750.00	329,949,530.00	315,274,200.00	313,581,291.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	297,163,584.00	286,884,330.00	287,744,300.00	286,051,391.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	194,073,600.00	194,147,592.00	198,291,200.00	198,164,162.00
210101	Үндсэн цалин	178,229,600.00	178,303,592.00	181,714,000.00	181,586,962.00
210105	Гэрээт ажлын хөлс	15,844,000.00	15,844,000.00	16,577,200.00	16,577,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,697,300.00	22,621,800.00	23,895,900.00	23,839,520.00
210201	Тэтгэврийн даатгал	14,962,037.00	16,891,640.00	15,641,368.00	15,682,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,547,093.00	1,145,852.00	2,040,008.00	1,989,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,933,656.00	1,433,215.00	1,637,006.00	1,637,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	386,774.00	286,463.00	490,702.00	490,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,867,740.00	2,864,630.00	4,086,816.00	4,040,420.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,262,000.00	14,260,501.00	18,507,900.00	18,334,129.00
210301	Гэрэл, цахилгаан	2,700,000.00	2,700,000.00	4,398,600.00	4,224,829.00
210302	Түлш, халаалт	11,562,000.00	11,560,501.00	14,109,300.00	14,109,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,338,914.00	18,338,400.00	18,702,500.00	18,702,423.00
210401	Бичиг хэрэг	2,455,700.00	2,464,700.00	3,035,500.00	3,035,500.00
210402	Тээвэр, шатахуун	11,593,614.00	11,594,200.00	10,603,000.00	10,603,000.00

Өлзийт сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,300,000.00	3,300,000.00	2,970,000.00	2,969,923.00
210404	Ном, хэвлэл	600,000.00	590,000.00	490,000.00	490,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	389,600.00	389,500.00	1,604,000.00	1,604,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,956,700.00	2,956,700.00	5,990,700.00	5,989,100.00
210602	Тавилга	00.00	00.00	3,700,000.00	3,700,000.00
210604	Урсгал засвар	2,956,700.00	2,956,700.00	2,290,700.00	2,289,100.00
2107	Томилолт, зочны зардал	2,998,000.00	2,998,000.00	3,696,000.00	3,688,000.00
210702	Дотоод албан томилолт	2,998,000.00	2,998,000.00	3,696,000.00	3,688,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,037,070.00	25,761,337.00	13,811,200.00	12,494,557.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,823,570.00	23,549,445.00	13,150,100.00	11,838,907.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00	220,000.00	220,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	100,000.00	100,000.00	100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	193,500.00	191,892.00	221,100.00	219,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	30,000.00	30,000.00	25,750.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,800,000.00	1,800,000.00	00.00	00.00
210807	Газрын төлбөр	90,000.00	90,000.00	90,000.00	90,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5800000.00	5800000.00	4848900.00	4839500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,300,000.00	5,300,000.00	4,148,900.00	4,141,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	500,000.00	700,000.00	698,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45768166.00	43065200.00	27529900.00	27529900.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00	26,729,900.00	26,729,900.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	00.00	26,729,900.00	26,729,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,768,166.00	43,065,200.00	800,000.00	800,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,297,466.00	15,594,500.00	00.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,670,700.00	19,670,700.00	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,800,000.00	7,800,000.00	800,000.00	800,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	342,931,750.00	329,949,530.00	315,274,200.00	313,581,291.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	340,543,320.00	326,798,530.00	314,674,200.00	311,370,491.00
132001	Орон нутгийн төсвөөс	340,543,320.00	326,798,530.00	314,674,200.00	311,370,491.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,388,430.00	3,151,000.00	600,000.00	2,210,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,388,430.00	3,151,000.00	00.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00	600,000.00	2,210,800.00

Өлзийт сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	26.00	26.00	26.00
620001	Удирдах ажилтан	09.00	09.00	09.00	09.00
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00	12.00	12.00
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	05.00	05.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	26.00	26.00	26.00	26.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	09.00	09.00	09.00	09.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	04.00	04.00	04.00	04.00
650010	Гэрээт ажилтан	05.00	05.00	05.00	05.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	08.00	08.00	08.00	08.00